



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/205

Хужирт сум

Засмал болон явган хүний замын
хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх
талбайн хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.12, 10 дугаар зүйлийн 10.2.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төв дэх засмал болон явган хүний зам, авто зогсоолын дагуух хог хаягдал, цас мөсийг цэвэрлэх аж ахуйн нэгж, байгууллага, худалдаа үйлчилгээний газруудын хуваарьт газрын хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Аж ахуй нэгж, байгууллага, худалдаа үйлчилгээний газруудыг дээрх хуваарийн дагуу шуурхай ажиллуулах арга хэмжээ авч ажиллахыг "Хужирт Эрдэс баялаг" УТҮГ-ын дарга (Ж.Шижээ), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бямбасүрэн), Замын цагдаа, ахлах дэслэгч (И.Бадрахзул), 4, 5 дугаар багийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Хавсралтад заасан хэмжээ, зургийн дагуу цэвэрлэх ажлыг байнга тогтмолжуулан хэвшүүлж ажиллахыг худалдаа үйлчилгээний газрууд, аж ахуй нэгж, байгууллагын захирал, эрхлэгч тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.



ДАРГА Д.БАТБАЯР

622301411

D:Alban bichig;Zahiramj 2023